

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3

“Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/ 3

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
12 дугаар сарын 25-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 12 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: О.Амгаланбаатар, Б.Дэлгэрсайхан, Л.Энхнасан, Д.Энхтүвшин, Р.Эрдэнэбүрэн.

“Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хаалттай горимоор хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул хуралдаан хаалттай горимд шилжив./16:15/

Нээлттэй хуралдаан 03 минут үргэлжилж, 25 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 15 минутад хаалттай горимд шилжив.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон "Их засаг" танхим
16 цаг 12 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Та бүхэнд ирц танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Батын Батбаатар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Нанзадын Наранбаатар гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Нямтайширын Номтойбаяр гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Жадамбын Энхбаяр гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал 1 асуудал байгаа. Хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Монгол Улсын Улаанбаатар хотын дулааны III дугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг, төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах асуудал байгаад байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Энхбаяр гишүүн байна. Энхбаяр гишүүний микрофон өгье.

Ж.Энхбаяр: Энэ төсөлтэй холбоотойгоор зарим мэдээллийг гишүүдэд өгмөөр байна. Тэгэхээр Байнгын хорооны даргаа энийг хаалттай горимд шилжүүлж өгөөч, хаалттай горимд яримаар байна. Тэгээд гишүүд нэг сайн ярилцаад авмаар байна. Энэ нэг тийм улс төржих салбар биш, нэг сайн тодруулж асуугаад, сайн ярьцаагаад, бодит эрчим хүчнийхээ салбарынх нь нөхцөл байдал, гадаад, дотоод учир шалтгаан гээд. Би зарим мэдээ байгаа, мэдээллээ хуваалцаад, тэгээд нэг сайхан шийдчихвэл.

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүн горимын санал гаргасан байна. Тэгэхээр Энхбаяр гишүүний горимын саналаар санал хураалтыг явуулна. Хаалттай горимд шилжүүлэх горимын саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалт. 58,8 хувь нь дэмжлээ. Ингээд хаалттай горимд шилжүүлэх бэлтгэл ажлыг хангая. Зохион байгуулалт, Байнгын хороо бэлтгэл ажлыг хангаарай.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА